

“МОН-НАБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“МОН-НАБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 08 -ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4- р хороо ЗГ-н 11-р байр 118 тоотод болов. Хурал 14.00 цагаас эхлэж ТУЗ –н дарга Р.Зоригт даргалан явуулав.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигч:

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
- Л.Пүрэв / 137 ширхэг хувьцаа эзэмшигч /
- З.Бүдсүрэн / 137 ширхэг хувьцаа эзэмшигч/

нар тус тус хүрэлцэн ирж, ирц 81.5 хувьтай байв.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт ;
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хуралд “Компанийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлт” - ийг ТУЗ-ийн дарга Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

Хувьцаа эзэмшигчид 2020 онд ээлжит хурлаа хийсэн. Бид энэ байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг бүрэн дүүрэн явуулж ажиллах хэрэгтэй байна.Өр төлбөрөө яаж ямар арга замаар төлж барагдуулж дуусгах талаар та нар санал хэлэх байх. Санхүүгийн хүндрэлээс шалтгаалан дулаанаа авч чадаагүй. ДШС- нээс ялтсан бойлуур тавихыг шаардаж ийм бойлуур тавихгүй бол дулаанаар хангах боломжгүй гэсэн. СЗХороо, Хөрөнгийн Биржээс ирүүлсэн албан тоот, даалгаваруудад хариу өгөх талаар их анхаарч ажилласан. Конторын барилгын дээврийн засварласан граж , дулааны үзелийн барилга, гадна болон дотор дулааны шугамын засварын ажил хийх шаардлагатай байгаа. Манай ойр хэвийн байгууллагуудын дулаан авдаг төв шугам дахин хагарч бүгд нийлж хагарсан шугамыг солисон . Компанийн өдөр тутмын асуудлыг шийдвэрлэж бүх л ажлыг Оюун-Эрдэнэд хийж байна. Жил бүр төлдөг урсгал зардлуудыг эзний өөрийн хөрөнгөөр төлж барагдуулж байгаа.Өнгөрсөн жилийн хийсэн ажлууд ийм байна гэв.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв. Үүнд:

Ш.Оюун-Эрдэнэ: СЗХороо, ХБиржээс маш олон мэдэгдэх хуудас,шаардлагууд ирсэн. Тэр болгонд хариу өгөх шаардлагатай болдог. СЗХорооноос ирүүлсэн даалгаварт сүүлийн 3 жил дотор хөрөнгийн үнэлгээ хийлгээгүй бол дахин үнэлгээ хийлгэж ирүүл гэсэн байсан .

Р.Зоригт: Ер нь манай компани сүүлийн жилүүдэд ямарч ажил хийгээгүй ямарч хөрөнгө нэмээгүй хөрөнгө үнэлгээ хийлгэх шаардлагагүй гэж бодож байна.

Р.Алтанцэцэг: Энэ жил санхүүгийн тайлан балансаа “ЭНИЧ АУДИТ”ХХК –аар аудитын гэрээ хийж дүгнэлт гаргуулсан хойшид хамтран ажиллах болно.Энэ байгууллагын ажил төрөл ямар байдлаар яаж ашигтай ажиллуулбал зүгээр талаар оновчтой санал хэлэх хүн байна уу.

Ш.Оюун-Эрдэнэ Төслийн ажил хөөцөлдөөд гадагшаа явсан хүн юу болсон бэ.Компанийн ТУЗ н гишүүд компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдах хэрэгтэй байна.Энийг СЗХорооноос шаардаад байгаа.

Л.Амарсайхан: Миний хувьд хуралд оролцож тайлан сонслоо . Хувьцаа эзэмшигчид хуралдаа муу оролцож байна. Хуралд ирж байгаа хүмүүс нь ноогдол ашиг тараах тухай их асуух юм.Үндсэн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл энээ тэрээ юм шаарддаг юм бол өөр жижиг ажил хийвэл болохгүй юу.Ажиллах боловсон хүчин хэрэгтэй, сайн ажилчид хэрэгтэй . Зээл авах талаар хөөцөлдсөн юм байнй уу..

Р.Зоригт: Төслийн ажлын хувьд бүтэмж муу байна.Явсан хүн ковидын хорионд ороод их ихугацаа алдаж байж ирсэн.Буцаж явах боломжгүй болсон.Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байгаа.

Р.Алтанцэцэг: 3% зээлийн шаардлагад манай байгууллага нийцэхгүй байгаа.ТУЗ-н хувьд гишүүдээ ажлуулмаар санал бодлыг сонсож тусламж дэмжлэг авмаар байна . Р.Зоригт ТУЗ-н даргын хувьд ч хувьцаа эзэмшигчийн хувьд ч идэвхи гарган янз бүрийн юмны өмнө л байх юм . Ш.Оюун-Эрдэнийг чөлөөлөгдөх хүсэлтийг яаж шийдэх юм бэ.Энэ хүн чинь бас амьдралтай хүн шүү дээ гэдгийг мартаж болохгүй.

Р.Зоригт: Ш.Оюун-Эрдэнийг одоогоор ажиллуулж байхгүй бол өөр хүн алга.Харин цалин шийдэж өгөх гэхээр санхүүгийн хувьд боломжгүй байна. Энэ жил ч энэ байдал хэвээр байх бололтой тиймээс тэсэж байхыг хүсье. Тусгай зөвшөөрөл өгөхгүй байна.Татварын өрийн асуудал олон шатны шүүхээр яваад байна.

Ш.Оюун-Эрдэнэ Хувьцаа эзэмшигчид хурлын зар, бичиг баримт хуралд хэлэлцэх асуудал,байгууллагын өнөөгийн байдлын талаар мэдээллийг олон сувгаар авах боломжтой.

Л.Амарсайхан: Цаашид ямар ажил төлөвлөж байна вэ? Инженер, техникийн ажилтнууд байна уу ?

Р.Алтанцэцэг: Бид энэ компанийн ажлыг өөднө татаж цаашид юу хийж яаж ажиллах талаар сайн ярилцмаар байна. ТУЗ-н хурал хийхээр ирчээл бусад үед оролцоо муу байна.

Р.Зоригт: Ер нь бол компанийг зориулалтын нь дагуу ажиллуулна. Энэ бол миний, та нарын хөрөнгө. Одоогийн инженер техникийн ажилтнууд цалин өндөртэйгээр бусад газруудад ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь хадгалаад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийн ажил хийнэ гэдэг хэцүү. Хөрөнгө оруулалтын ажлаа ийшээ чиглүүлнэ гэсэн бодолтой. Энэ жил ажил хүндхэн байх төлөвтэй байна.

Л.Пүрэв: Би хурлын хэлэлцэж байгаа асуудалтай санал нэг байна.Цаашдаа сайн ажиллах хэрэгтэй шүү хүүхдүүд минь.Хурлаас гарах шийдвэрийг дэмжинээ.

Ш.Оюун-Эрдэнэ: Энэ хуралд хараат бус гишүүд оролцож байгаа санал хүсэлт хэлэх байхаа

Д.Болорцэцэг:ТУЗ-ийн ажил муу байсан гэдгийг сануулах хэрэгтэй. Хөрөнгө оруулалт татах хэрэгтэй юм шиг санагдах юм.ТУЗ-н гишүүд идэвхи санаачлага муутай байна.

Миний хувьд жил бүр хуралд ирдэг. Хувьцаа эзэмшигчид шүүмжлээд байхаас биш бид ямар үүрэгтэй байх вэ яавал энэ байгууллагыг сайн болгох тухай олигтой санал хэлдэггүй. Зарим нэг хүмүүс нь бүр доромжлоод хурлаа хаяад гардаг. Сайн менежмент хэрэгтэй гэж бодож байна. Ямар менежментээр яаж ажиллах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй.

Г.Төгөлдөр : Хувьцаа эзэмшигчид ноогдол ашиг тараах уу гэж их асуудаг. Бид энэ компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох боломж байдаггүй өөр өөрийн ажлаа хийгээл явж байдаг. Байгууллагаа яаж ажилтай байлгах уу гэж боддоггүй. Туслаад дэмжээд ажиллах хүн алга. Зарим хувьцаа эзэмшигчид боломжтой хамтраад ажил хийвэл болох юм шиг санагддаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэв. Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэн батлахтай холбогдуулан Р.Зоригт өөрийн саналаа хэлэв:

- 2021 онд Санхүүгийн байдлаа сайжруулах өр төлбөрийн асуудлаа шийдвэрлэх;
- Төслийн ажлын гэрээ санхүүжилтыг баталгаажуулах;
- Гадна болон дотор дулааны шугамын засварын ажлыг бүрэн дуусгах;

Компанийн тухай хуулийн 77р зүйлийн 77.2, Компанийн дүрмийн 10.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-н гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дараагийн ээлжит хурал хүртэл сунгаж дэд хороодууд хуучин бүрэлдхүүнээрээ ажиллахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал нэгтэй батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг хэлэлцэж, тэдгээрийг санал нэгтгэйгээр батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА

Р.Зоригт

Р.Зоригт

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Д.Болорцэцэг

